

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАЗРЫН 2018 ОНЫ 07 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 07 дугаар сарын 26

Замын-Үүд сум

Тус газар нь МУ-ын Хилийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2010 оны 338, 339, 340 журам тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актууд, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал, албан даалгаврыг тус тус удирдлага болгон гадаадын иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилэхэд анхаарч 2018 оны 06 сарын 16-ны өдрөөс 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1 Монгол Улсын виз, зөвшөөрөл, хяналт шалгалтын талаар:

Тайлант хугацаанд гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон байна. Үүнд: дамжин өнгөрөх виз 23 иргэн, нэг удаагийн орох виз 4 иргэн, визийн шилжүүлэг 10 иргэн, нэг удаагийн гарах-орох виз 38 иргэн, Алдаатай олгогдсон виз засварласан 6 иргэн түр ирэгчийн бүртгэл 25, хасалт 22, оршин суух зөвшөөрлийн хасалт 29 хийсэн.

1.2 Хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын иргэдийн талаар:

Тайлант хугацаанд давхардсан тоогоор хил орчмын нутагт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын 1434 иргэн зорчсон байх бөгөөд Монгол Улсад байх хугацаа, зорчих нутаг дэвсгэрт бүртгэлээр хяналт тавьж ажилласан.

1.3. Алдаатай визийн талаар:

Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд болон Төвөөс алдаатай олгогдсон БНХАУ-ын 12 иргэний визийг илрүүлэн, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

1.4. Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар:

БНХАУ-ын 28 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч, мэдээллийг нь зохих хугацаанд Төвд хүргүүлж ажилласан.

1.5. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1.6, Засгийн Газрын 2010 оны 338 дугаар тогтоолын 4.1-ийн дагуу Монгол улсад байх, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй 2 орны 44 иргэнийг улсын хилээр оруулалгүй буцаан ажилласан.

1.6. Захиргааны арга хэмжээ авсан талаар

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн 2 орны 9 иргэнийг 660.0 мянган төгрөг, 10 аж ахуйн нэгж байгууллагын 24 иргэнд 1,230.0 мянган төгрөг, 2 уригч иргэний урьсан 2 иргэнийг 20.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд Дорноговь аймаг дахь газрын дарга 4 тушаал батлан гаргасан ба үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээ, тус газрын сар бүрийн үйл ажиллагааны тайланг гаргаж Боомт, орон нутгийн газарт хэлтэст тус тус хүргүүлэн ажиллаж байна.

2.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар

Дорноговь аймаг дахь газар нь албан хэрэг хөтлөлтийн ажилладаг “Хяналтын карт”, ирсэн бичиг, өргөдөл, гомдолд “Бүртгэл хяналтын карт”-ыг тухай бүр хөтөлдөг ба хариутай албан бичгийг стандартын дагуу боловсруулдаг болно.

Тайлант хугацаанд тус газрын бичиг хэрэгт 13 албан бичиг ирснийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 5 албан бичгийн 5 бичгийн хариу өгч, 11 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Албан хаагчдаас чөлөө хүссэн 2 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн. Харин тус газарт ирсэн гомдол байхгүй болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтад 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдөр өөрчлөлт орсонтой холбогдуулан ГИХГ-ын даргын энэ оны Б/51 дүгээр тушаалаар тус газрын батлагдсан орон тоо 28 бөгөөд бүртгэлтэй байгаа 24 албан хаагчаас 23 албан хаагч ажиллаж байна. Үүнээс хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагч байна.

“Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль”-иар 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр газрын захиргааны мэргэжилтэн сургалт зохион байгуулж сургалтаар гэр бүлийн хүчирхийлэл түүнээс үүсэх үр дагаврын талаар албан хаагчдад зохих мэдээ мэдээллийг олгож сургалтанд нийт 8 хаагч хамрагдсан.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар


Тайлант хугацаанд батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 37,701.6 мянган төгрөгийн санхүүжилт орсноор 31,866.5 мянган төгрөгийн зарлага гаргасан. Үүнээс цалин хөлс 26,012.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 3,143.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 2,711.2 мянган төгрөгийг зарцуулан ажилласан.

Гурав. Бусад

Хилийн 0108-р ангийн шалгагч бүрэлдэхүүнд 2018 оны 07 сарын 23-ны өдөр Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Б.Цогтбат-Очир нь Засгийн газрын 2018 оны 145, 146 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-р сургалт зохион байгуулж шалгагч бүрэлдэхүүнд зохих мэдлэгийг олгосон.

Дотоод нөөц бололцоогоо ашиглан газрын байрны хойд талын газрыг тэгшилж цемэнтэн цутгамал хийж авто машины зогсоол, хашаа, сүүдрэвч, цэцгийн мандал зэргийг хийж гүйцэтгэсэн.

Авто машины зогсоолын хашаа



Байгууллагын урьд хойд талд мод тарьсан

